



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/81

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх Дарив сумын нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугмын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Алтанзагас (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд: Р.Нямжаргал (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын, Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн)

Г.Ууганбаатар (Хөндлөнгийн төлөөлөл (тохиролцсон))

Нарийн бичиг: Ё.Нарангарав (Есөнбулаг сумын иргэн)

Б.Эрхбаяр (Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Д.Алтанзагас)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

